

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БУА-2020/07/-НА

БУЛГАН ХОТ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг:
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг:
Ахлах аудитор Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг:
Аудитор З.Ганбаатар

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 433

Булган

Нийцлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2 заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаал, 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, 2018 оны А/221 дүгээр тушаалаар баталсан "Аудитын чанарын хяналтын журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын сэдэв шинэчлэн батлах тухай" 2020 оны А/53 дугаар тушаалын дагуу "Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Нийцлийн аудитын тайланг аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 20-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, биелэлтийг тооцон хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ж.Энхцоодол/-д даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг нийцлийн аудитын албаны ахлах аудитор /Г.Намчинсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Д.АНХБАЯР



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт, аудитын бүрэлдэхүүн, хугацааны мэдэгдэл.....	4-6
Бүлэг 1. Ой хамгаалах нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр аймаг, орон нутгийн захиргааны байгууллага хууль заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх.....	6-8
Бүлэг 2. Ойн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг хууль журмын дагуу төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх.....	8-12
Бүлэг 3. Ойн нөхөн сэргээлт үр дүнтэй эсэх.....	12-13
Бүлэг 4. Ойн нөхөрлөл, Аж ахуйн нэгж, ойн ангиуд хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, холбогдох байгууллагууд хуульд заасан холбогдох хяналтыг хэрэгжүүлсэн эсэх	13-15
Дүгнэлт.....	15
Зөвлөмж.....	15-16

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын их хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний Аудитын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
БОАЖЯ	Байгаль, орчин, аялал, жуулчлалын яам
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НА	Нийцлийн аудит

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Аудитын зорилт

**Аудитын хамарсан
хүрээ**

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн
талаарх мэдэгдэл**

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн УИХ-ын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2019 оны 05 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын 2020 онд хийх аудитын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

Ойн тухай хуулийн 2018-2019 оны үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг аймгийн Засаг дарга, ИТХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтын хүрээнд дараах дэд зорилтын дагуу аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Ой хамгаалах нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр аймаг, орон нутгийн захиргааны байгууллага хууль заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн эсэх
- Ойн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг хууль журмын дагуу төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх
- Ойн нөхөн сэргээлт үр дүнтэй эсэх
- Ойн нөхөрлөл, ойн ангиуд хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, холбогдох байгууллагууд хуульд заасан холбогдох хяналтыг хэрэгжүүлсэн эсэх

Тус аудитад БОАЖГ болон тэдгээрийн харьяа холбогдох байгууллагууд, аймаг, сум, ИТХ, Засаг дарга, аймаг, сумын Санхүү төрийн сангийн хэлтэс, сумдын ойн анги болон, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагад Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүнд хийгдэх аудитад улс, орон нутгийн төсвөөр хийгдсэн нөхөн сэргээх, үржүүлэх зориулалтаар хийгдсэн ажлыг 2016-2019, Хэрэглээний болон түлшний модны эрхийн бичгийн орлогыг 2018-2019 оны тус тус хамруулан шалгана

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100-400, 4000, 4100 дугаар стандартууд болон Төрийн хяналт шалгалтын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан Нийцлийн аудитын түр журмыг баримтлан аудитад хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын байгаль орчны нөхөн сэргээлттэй холбогдох баримт материал, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, дүрэм, журам, зааврыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана. Үүнд:

- Захиргааны ерөнхий хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль
- Ойн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 43 дугаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх зарцуулах зарцуулах, тайлагнах журам”

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа:

Аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг 2020 оны 05дугаар сарын 01-ны өдрөөс, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 04-ны өдрөөс, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс, тайлагналын үе шатны ажлыг 06 дугаар сарын 23-ны өдрөөс тус тус эхлүүлэн гүйцэтгэж, аудитын нэгдсэн тайланг 2020 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан ИТХ, аймгийн ЗД хүргүүлэхээр байсан. Үндэсний аудитын газраас 2020 оны аудитын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан бөгөөд тухайн тайлангийн гүйцэтгэлийн шатанд нэгдсэн удирдамжтай /хуулийн хугацаанд хийж гүйцэтгэх/ аудитуудыг гүйцэтгэх болсонтой холбогдуулан тэргүүлэх аудиторын тушаалаар аудитын хугацааг сунгасан болно.

Аудитыг гүйцэтгэсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Намчинсүрэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Хүндрэл бэрхшээл

ҮАГ 2020 хийж гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулснаар тухайн аудитыг хойшлуулсан, тухайн аудитыг хийж гүйцэтгэхэд нэг аудиторыг хийж гүйцэтгэхээр оруулсан нь аудитыг цаг хугацаанд, төлөвлөсөн зорилгодоо хүрсэн үр дүн гаргахад хүндрэлтэй байлаа.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн хэмжээнд Ой сан бүхий 12 суманд хэрэглээний зориулалтаар 2018 онд 17040, 2019 онд 13770, иргэд, аж ахуйн нэгжийн түлшний зориулалтаар 2018 онд 93089, 2019 онд 96763 м.куб мод бэлтгэхээр тус тус баталжээ. 2020 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 215 нөхөрлөл, 35 аж ахуйн нэгж байгууллага бүртгэлтэй байна.

Бүлэг 1

Аймаг, орон нутгийн захиргааны байгууллагын хуульд заасан чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

1.1.1. Аймаг, сумын ИТХ нь хуулиар хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймаг, сумдын ИТХ-ын үүргийг ойн тухай хуулийн 17.1.4¹, 17.1.5², 32.2³, 18.1.3⁴, 18.1.5⁵, 18.1.6⁶, дахь заалтад тус тус тодорхойлжээ.

Аймгийн ИТХ нь 2018, 2019 онд ойгоос мод бэлтгэх модны дээд хязгаар, ойжуулалтын талбайн хэмжээ, ойжуулалт хийх зардлыг тус тус баталсан нь ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, 32.2 дахь заалттай нийцэж байна.

Аймгийн ИТХ нь 2019 оны ойн хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлаагүй, ойн сан бүхий 12 сумын ИТХ нь Засаг даргаас хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцээгүй, үйл ажиллагаа явуулж буй ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлсэн гэрээний биелэлтийг дүгнэдэггүй, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд хяналт тавиагүй, Ойн тухай хуулийн 17.1.5, 18.1.3, 18.1.5, 18.1.6 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1.2. Аймаг, сумдын Засаг дарга нар ойн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

¹ төрийн захиргааны төв байгууллагын баталсан дээд хязгаарт багтаан тухайн жилд ойгоос бэлтгэх хэрэглээний мод, түлээний хэмжээг сумдаар хуваарилан батлах;

² Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нутаг дэвсгэртээ ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, шаардагдах төсвийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

³ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээг энэ хуулийн 32.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүрэг бүрээр тогтооно

⁴ Ойг хамгаалах талаар Засаг даргаас хэрэгжүүлсэн ажлын тайлан хэлэлцэх, шийдвэр гаргах;

⁵ Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшүүлсэн гэрээний биелэлтийг жил бүр хэлэлцэн дүгнэж байх;

⁶ Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх бодлого, чиглэлийг батлах, хяналт тавих;

Аймаг, сумдын Засаг даргын үүргийг ойн тухай хуулийн 17.2.2⁷, 17.2.4⁸, 17.2.10⁹, 18.2.6¹⁰, 18.2.7¹¹, 18.2.8¹² дахь заалтад тус тус хуульчилжээ.

Аймаг, сумдын Засаг дарга нар 2016 онд хэрэгжүүлэх хугацаа нь дууссан ойн менежментийн төлөвлөгөөгөөр тухайн жилд бэлтгэх модны дээд хязгаарыг төлөвлөн баталсан, аймгийн Засаг дарга 2019 оны ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын төлөвлөгөөг батлуулаагүй, сумдын Засаг дарга БОУХБ-тай хамтран хяналт шалгалтын удирдамж батлан хяналт зохион байгуулдаг ч мод бэлтгэлийн гүйцэтгэл, үйл ажиллагаа явуулж буй ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын гэрээний биелэлтэд огт хяналт хийдэггүй, Ойн тухай хуулийн 17.2.2, 17.2.10, 18.2.4, 18.2.6, 18.2.8, дахь заалтыг огт хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1.3 Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн ч зарим ажлыг хангалтгүй гүйцэтгэсэн байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын үүргийг ойн тухай хуулийн 17.3.2¹³, 17.3.3¹⁴, 17.3.9¹⁵ -дахь заалтад тус тус тодорхойлжээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/299 тоот тушаалын дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 04, 2019 оны 07 тоот тогтоолоор тухайн онуудад ойгоос бэлтгэх модны хуваарийг тус тус батлуулсан байна.

Ойн тухай хуулийн 17.3.2, 17.3.3, 17.3.9 -д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, хавар, намрын мод тарих ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн баримтын бүрдлийг архивын нэгж болгоогүй, шаардсан баримтыг цаг хугацаанд ирүүлээгүй, ирүүлсэн баримт материал баталгаажаагүй байна.
- Аймгийн хэмжээнд мод бэлтгэх эрх бүхий 35 аж ахуйн нэгж, байгууллагаас 2018 оны ойн менежментийн төлөвлөгөө тайланг БОАЖГ гаргуулж аваагүй, 2019 онд 8 аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөнөөс өөр холбогдох баримт материал байхгүй байна.
- Харьяа сум дундын Ойн ангийг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд хяналт тавих ажлыг зохион байгуулдаггүй,
- Жил бүр мод тарих үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байгаа ч суулгасан тарьцыг хүлээж авсан, хүлээлгэн өгсөн, амьдралын хувийг тооцоогүй, арчлалт хамгаалалтгүй байна.

⁷ Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, биелэлтийг хангах"

⁸ тухайн жилд ойгоос бэлтгэх модны хэмжээний талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

⁹ Ой бүхий сум, дүүргийн ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

¹⁰ энэ хуулийн 18.1.4-т заасан шийдвэрийг үндэслэн ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад ойн сангийн тодорхой хэсгийг болзол, хугацаатайгаар эзэмшүүлэх гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

¹¹ ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг үндэслэн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон хязгаарт багтаан мод бэлтгэх шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хяналт тавих;

¹² Ойн нөөцийн бүртгэл, ой зохион байгуулалтын ажлыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэртээ ойн мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, сумын ойн менежментийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх;

¹³ Аймаг, нийслэлийн ойн мэдээллийн санг бүрдүүлж, төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах;

¹⁴ Өөрийн харьяа ойн ангийг мэргэжлийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

¹⁵ Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

- Ойн судалгаа хөгжлийн төвд 2018 онд 2031.1 м3 илүү, 2019 онд 96.1 м3 дутуугаар хэрэглээний мод бэлтгэлийн гүйцэтгэлийн мэдээг хүргүүлсэн / хавсралт 1/

Дээрх зөрчлүүдээс дүгнэхэд БОАЖГ-ын албан тушаалтан, мэргэжилтний хяналт, ажлын хариуцлага, санал санаачилга хангалтгүй байгааг харуулж байна.

Бүлэг 2

Ойн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг хууль журмын дагуу төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

2.1.1. Сумдын түвшинд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос ойг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхгүй байна.

Орон нутгийн төсвөөс ойн нөхөн сэргээх зардалд хуваарилсан хөрөнгийг “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-д заасан хэмжээгээр тооцож үзэхэд 2018 онд 255.7, 2019 онд 252.0 сая төгрөгийг тус тус хуваарилахаас 2018 онд 1499.8, 2019 онд 978.1 сая төгрөгөөр тус тус төлөвлөжээ.

Ойн нөхөн сэргээх зардалд зарцуулахаар хуваарилсан хөрөнгө

Хүснэгт 1 /Сая.Төг/							
№	Орлогын төрөл	Огноо	Жилийн батлагдсан орлогын дүн	Ойг нөхөн сэргээхэд зарцуулахаар батлагдсан дүн	Орлогын хувь, хэмжээний доод хязгаар	Хуулийн дагуу нөхөн сэргээхэд зарцуулах дүн	Зөрүү /Илүү (дутуу)/
1	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	2018	300.8	1499.8	300.8	255.7	1244.1
2	Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого	2019	296.5	978.1	85%	252.0	726.1
Нийт дүн			1970.2	597.3	2477.929	301.65	507.7

Хүснэгтээс үзэхэд аймгийн хэмжээнд 2018 онд 1499.8, 2019 онд 978.1 сая төгрөгийг Ойн нөхөн сэргээхэд зарцуулахаар баталж ажилсан нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1¹⁶ дэх заалттай нийцэхгүй байна.

Харин сумын Засаг дарга, ИТХ ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос хуульд заасан хэмжээгээр ойн нөхөн сэргээх зардалд зарцуулах төсвийг батлахгүй, орон нутгийн урсгал зардалд зарцуулж байгаа нь Байгалийн нөөц ашигласны

¹⁶ .Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно:

төлбөрийн тухай хуулийн 13.1¹⁷, 13.4¹⁸, Ойн тухай хуулийн 18.1.1¹⁹, 18.2.2²⁰, Төсвийн тухай хуулийн 6.6.6²¹, ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 2.2²² дахь заалтуудыг зөрчиж байна.

2.1.2. Ойн нөөцийн төлбөр хураамжийг хуулийн дагуу тооцож төлөвлөдөг ч ойн дагалт баялгийн орлогын төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлээс тооцож төлөвлөсөн байна.

Аймгийн хэмжээнд Засгийн газрын 2017 оны 307 дугаар тушаалаар баталсан “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” журмын дагуу мод бэлтгэх хэмжээг 2018 онд 110129 м3, 2019 онд 110533 м3-ээр тус тус баталсан ба орлогын төлөвлөгөөг 2018 онд 300800.0, 2019 онд 296510.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна. /Хүснэгт 1/

Ойн дагалдах баялгийн орлогыг төлөвлөхдөө бодитой тоон мэдээ, судалгаанд үндэслэдэггүй өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан баталдаг нь Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А/125 дугаар тушаалаар “Ойн дагалт баялгийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээг тогтоох тухай” заавартай уялдуулж төлөвлөөгүй байна.

2.2.1. Аймгийн хэмжээнд орлогын төлөвлөгөө биелсэн ч зарим сумдын хувьд орлого тасарсан байна.

Ой сан бүхий 12 суманд ойн нөөц ашигласны төлбөрийг 2018 онд 300800.0, 2019 онд 296510.0 мянган төгрөгөөр тус тус баталж төсөвт төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 2018 онд 319281.0, 2019 онд 314679.0 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 2018 онд 107.6, 2019 онд 106.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

2018-2019 оны ойн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 2 /мян.төг/

Сумдын нэрс	2018 оны төлөвлөгөө	2018 оны гүйцэтгэл	2018 зөрүү	2019 оны төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл	2019 зөрүү
Баян-Агт	21000	25047	-4047	19638	20252	-614
Бугат	44700	48432	-3732	36445	56879	-20434
Бүрэгхангай	7000	10664	-3664	7000	11852	-4852
Могод	4100	3683	417	4445	4143	302
Орхон	36500	35736	764	31374	31902	-528
Сайхан	9100	4472	4628	7018	5274	1744

¹⁷ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсэгт /цаашид “төлбөрийн орлогын хэсэг” гэх/ төсвийн жилд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор хуваарилсан байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын тодорхой хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө багтана.

¹⁸ Энэ хуулийн 13.1-д заасан төлбөрийн орлогоор санхүүжүүлж хэрэгжүүлэх байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын өргөн мэдүүлснээр аймаг, нийслэл, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

¹⁹ ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийг түймрээс хамгаалах арга хэмжээнд шаардагдах төсвийг батлах, биелэлтэд хяналт тавих;

²⁰ ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх болон ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

²¹ Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх

²² Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь энэхүү журмын 2.1-д бүрдүүлсэн орлогын хэмжээнд үндэслэн тухайн жилийн төсвийн суурь зарлагын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна

Сэлэнгэ	44100	54744	-10644	59239	52832	6407
Тэшиг	44000	39892	4108	42560	38446	4114
Хангал	23800	24622	-822	23048	24402	-1354
Хишиг-Өндөр	10200	10534	-334	11445	12214	-769
Хутаг-Өндөр	55500	56633	-1133	53498	56214	-2716
Булган	800	4824	-4024	800	269	531
Нийт дүн	300800	319281	-18481	296510	314679	-18169

Ойн нөөц ашигласны орлогын төлөвлөгөө давж биелж байгаа нь ИТХ-аар баталсан модны дээд хязгаарыг баримталдаггүй, мод бэлтгэх дээд хязгаараас хэтрүүлэн олгодог, төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг тооцохдоо мод бэлтгэх талбайгаас гарах модны мөнгөн үнэлгээг тооцох боломжгүйгээс ойн нөөц ашигласны төлбөрийг дундаж үнэлгээгээр тооцон төлөвлөдөгтэй холбоотой байна.

Мод бэлтгэх эрхийн бичгээрх орлогын дүн нь төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнгээс бага, зөрүүтэй байгаа нь эрхийн бичиг түр байхгүй шалтгаанаар малчид, иргэдэд түлээний модыг олгохдоо эрхийн бичиггүй бэлтгүүлдэг зэргээс шалтгаалж байна.

Мөн түлээний модноос ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг дутуу тооцон төсөвт төвлөрүүлсэн зөрчил илэрлээ. Энэ нь “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох” журмын 2 дугаар хавсралтын дагуу ойн сангийн мужлалыг баримталж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Орхон сумын 1, 2, 3, 4, 5 дугаар багийн байгаль хамгаалагч нар нийт 6394.4,
- Хишиг-Өндөр сумын байгаль хамгаалагч нар нийт 660.0,
- Бугат сумын 1 дүгээр багийн байгаль хамгаалагч 670.6, 3 дугаар багийн байгаль хамгаалагч 2065.5 мянган төгрөгийг тус тус мужлалын дагуу тогтоох төлбөрийн хэмжээг зөв тогтоож ойн нөөцийн орлогыг төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар баталсан “Ойгоос мод бэлтгэх журмын” 3 дугаар зүйлийн 3.3²³, засгийн газрын 2014 оны А/307 тоот тогтоолоор “Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох” журмын 1²⁴ дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

Харин аудитыг гүйцэтгэх хугацаанд Сэлэнгэ сумын 5 дугаар багийн байгаль хамгаалагч 214 эрхийн бичгийн үнэ болох 3417.6 мянган төгрөгийг дутагдуулсан зөрчил илэрч төлбөрийн акт оногдуулан ажиллалаа.

2.2.2. Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэх эрх авсан нөхөрлөл, аж ахуй нэгж, байгууллага төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлдэггүй байна.

Аймгийн хэмжээнд сум дундын 3 ойн анги 2018 онд 2216.6 2019 онд 2460.2 га талбайд тус тус тусгаарлалтын ажлыг гүйцэтгэж 2018 онд 59714.8, 2019 онд 62094.5 мянган төгрөгийн орлогыг төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.

²³ Мод бэлтгэгч талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг урьдчилан төлж, “Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг”-ийг Ойн ангиас эсхүл сум, дүүргийн Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтнаас авна,

²⁴ Ойгоос хэрэглээний мод бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг 1 дүгээр, Ойгоос түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн хэмжээг 2 дугаар, Иргэн, аж ахуйн нэгж байгууллага ойн арчилгаа, цэвэрлэгээний аргаар түлшний мод бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь, хэмжээг 3 дугаар хавсралт ёсоор тогтоосугай.

Ойн ангийн өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 3 /мян.төг/

Сум дундын ойн ангийн нэрс	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Булган сумын сум дундын ойн анги	2018	9500.0	25973.2	-16473.1
	2019	13700.0	17585.5	-3885.5
Хутаг-Өндөр сумын сум дундын ойн анги	2018	7400.0	15722.7	-8322.7
	2019	14625.0	19087.7	-4462.7
Хялганат тосгон дахь сум дундын ойн анги	2018	8400.0	18019.0	-9619.0
	2019	7000.0	25421.3	-18421.3
Нийт дүн	2018	25300.0	59714.8	-34414.8
	2019	35325.0	62094.5	-26769.5

Ойн ангиуд нь орлогыг дутуу төлөвлөж байна. Сум дундын ойн ангийн орлогыг сум тус бүрд талбай тусгаарлалтын зардалд тулгалт хийснээр дараах сумдууд 2018-2019 онд нийт 10212.0 мянган төгрөгийг төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн. Үүнд:

- Баян-Агт сум 2018, 2019 оны дутуу 1135.0,
- Могод сум 2019 оны дутуу 460.0,
- Сайхан сум 2018, 2019 оны дутуу 2734.3,
- Тэшиг сум 2018, 2019 оны дутуу 1737.3,
- Хутаг-өндөр сум 2018, 2019 оны дутуу 4145.4 мянган төгрөгийг тус тус төсөв дутуу төвлөрүүлсэн байна.

Сум дундын ойн ангиуд нь талбай тусгаарлалтыг орлогыг бүрэн төвлөрүүлээгүй нь Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.13²⁵, “Ойгоос мод бэлтгэх журмын” 3 дугаар зүйлийн 3.3²⁶ дахь заалтыг тус тус зөрчиж байна.

2.2.3. Ойн дагалдах баялгийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Ой дагалдах баялгийн орлогыг 2018 онд 4 суманд 26900.0, 2019 онд 5 суманд 12432.5 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 2018 онд 5863.8, 2019 онд 7068.2 мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлж 2018 онд 21036.2, 2019 онд 5364.3 мянган төгрөгийн орлого тасар ч 2018 онд 21.8, 2019 онд 56.9 хувийн биелэлттэй байна.

Ойн дагалт баялгийн 2018, 2019 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 4 /мян.төг/

Ойн дагалт баялгийн орлогыг сумдаар		2018 он			2019 он		
Д/д	Сумын нэрс	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Орхон				1000	519.2	-480.8

²⁵ Ойн анги нь төсөв, түүнчлэн сургалт, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлсний болон өөрийн ажил, үйлчилгээний орлого зэрэг эх үүсвэрээс санхүүжих”

²⁶ Мод бэлтгэгч талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг урьдчилан төлж, “Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг”-ийг Ойн ангиас эсхүл сум, дүүргийн Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтнаас авна,

2	Сэлэнгэ	4640	2129.7	-2510.3	6000	1236	-4764
3	Тэшиг	20390	3229.8	-17160.2	5432.5	5313	-119.5
4	Хангал	1500	0	-1500	0	0	0
5	Хутаг-Өндөр	370	504.3	134.3	0	0	0
6	Нийт дүн	26900	5863.8	-21036.2	12432.5	7068.2	-5364.3

2.2.4. Мэргэжлийн байгууллагууд хамтарсан хяналт шалгалт хийж байгаа боловч 2018 оноос 2019 онд 8 хэрэг нэмэгдэж бүртгэгдсэн нь хяналт шалгалт төдийлөн үр дүнд хүрээгүй байна.

БОАЖГ нь 2018, 2019 онд мэргэжлийн байгууллага, байгаль хамгаалагчид, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Цагдаагийн газартай хамтарсан шалгалтаар аймгийн Цагдаагийн газрын хэрэг бүртгэлд тусгагдсан нийт 2018 онд 27, 2019 онд 35 хэрэг бүртгэгдсэнээс харьяаллын дагуу шилжүүлсэн 11, эрүүгийн хэрэг үүссэн 51 мэргэжлийн байгууллагаар экологи эдийн засгийн үнэлгээгээр 2018 онд 3827.7, 2019 онд 11895.5 нийт 15723.2 мянган төгрөгөөс гүйцэтгэлээр 2018 онд 3718.7, 2019 онд 6498.4 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлж зөрүү болох 5506.1 мянган төгрөгийн зөрчлийг хэрэгсэхгүй болгосон байна. Жил бүр хууль бусаар мод бэлтгэсэн хэрэг зөрчил нэмэгдэж байгаа нь ойн тухай хуулийг иргэд, олон нийтийн сүлжээнд сурталчлах мэдээлэх ажил хийгдээгүйтэй холбоотой байна, сум орон нутагт байгуулагдсан ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх шаардлагатай байна.

Бүлэг 3

Ойжуулалтын ажил үр дүнгүй байна.

3.1. Ойн нөхөн сэргээлтийн зардлыг сумд байгаль хамгаалах санд төвлөрүүлдэг ч зориулалтын дагуу зарцуулдаггүй байна.

Хэрэглээний модны ойн нөхөн сэргээлтийг Ойн тухай хууль 30.2²⁷, мод бэлтгэх журмын 7.7.2²⁸, мөн Байгаль орчин ногоо хөгжлийн сайд, сангийн сайдын хамтарсан 2013 оны 03 дугаар сарын 29- ны өдрийн А-96/71 журмын 4.1²⁹ -д заасны дагуу гүйцэтгэхээр заажээ.

Аймгийн хэмжээнд 2018 онд 10449.3 м3, 2019 онд 11187.9 м3 хэрэглээний мод бэлтгэснээс ойн нөхөн сэргээлт хийх талбайг тооцоход 2018 онд 156.7, 2019 онд 167.8 га талбайд гүйцэтгэхээр байсан байна.

Ойн нөөцтэй сумдад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хэрэглэсэн хэрэглээний модны нөхөн сэргээлтийн зардлыг мод бэлтгэх эрхийн бичгийн зөвшөөрлийн үнэн дээр 1м3-д 10425 төгрөгөөр тооцон сумын байгаль хамгаалах санд төвлөрүүлдэг, зарим аж ахуйн нэгж, байгууллагын хувьд нөхөн сэргээлтийг ойн

²⁷ Иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага огтолсон нэг модны оронд арав буюу түүнээс дээш тарьц суулгацыг ойд тарьж ургуулж, улсын ойн санд хүлээлгэж өгнө.

²⁸ шаардлагатай талбайд ойжуулах, нөхөн сэргээх ажил хийлгэх,

²⁹ Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлыг улсын болон орон нутгийн санхүүжүүлнэ. Мод бэлтгэдэг үйл ажиллагаа эрхэлдэг нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн хөрөнгөөр ойжуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

анги, тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж болон тухай аж ахуйн нэгж өөрсдөө хийж гүйцэтгэж байна.

Мод бэлтгэсэн аж ахуйн нэгж, байгууллага нь нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй, ойн нөхөн сэргээлтийн зардлыг төсөвт төвлөрүүлээгүй, ойн анги болон мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн нөхөн сэргээлт хангалтгүй, хууль зүйн үндэслэлгүйгээр ойн нөхөн сэргээлтийн төлбөрийн төвлөрүүлдэг, сумдын байгаль хамгаалах санд төвлөрсөн нөхөн сэргээлтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Баян-Агт сумын “Балигийн эх” ХХК 4.3, Сэлэнгэ сумын “Төгөл моностой” ХХК 2, “Цагаан хуст” ХХК 4, Хангал сумын “Өндөр хужирт” ХХК 1.9 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй тухайн аж ахуйн нэгж, байгууллага өөрсдөө гүйцэтгэсэн гэх боловч сумын холбогдох албан тушаалтанд хүлээлгэж өгөөгүй, ойжуулалт хийсэн тарьцын амьдралтын хувь ойролцоогоор 10 хувьд ч хүрэхгүй байна.
- Хутаг-Өндөр, Баян-Агт суманд нөхөн сэргээлтийн төлбөрийг аж ахуйн нэгж, байгууллагаас нөхөн сэргээлтийн зардлыг 50 хувиар тооцож төлүүлж байна.
- Хангал сум нь 2018, 2019 онд нийт 21.2 га талбайд мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлсэн ч ургалт нь ойролцоогоор 20 хувьтай байна.
- Ойн нөхөн сэргээлтийн зардлыг 2018 онд сумдын байгаль хамгаалах санд 38581.4, 2019 онд 73328.6 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн ч зориулалтын дагуу зарцуулдаггүй байна.

Бүлэг 4

Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, ойн ангиуд хууль тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

4.1.1. Ойн нөхөрлөл нь хууль, тогтоомж, гэрээгээр хүлээсэн үүргээ огт биелүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд нийт 215 ойн нөхөрлөл бүртгэлтэйгээс 63 ойн нөхөрлөл огт үйл ажиллагаа явуулдаггүй, ойн менежментийн төлөвлөгөө батлуулаагүй болон хугацаа дууссан 145 нөхөрлөл байгаа нь аймгийн хэмжээд ойн нөхөрлөлийн үйл ажиллагаа хангалтгүй байна.

Сумын Засаг дарга нар ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг ИТХ-аар хэлэлцүүлээгүй, ойн нөхөрлөлүүдтэй байгуулсан гэрээний биелэлтийг сумдын Засаг дарга дүгнээгүй, ойн нөхөрлөлүүд нь хууль тогтоомжид нийцсэн дүрэм, ойн менежментийн төлөвлөгөөгүй, үйл ажиллагаа явуулж байгаа нь

Ойн тухай хуулийн 17.3.9,³⁰ 21.1.³¹, 21.2.³², 21.3.³³, 21.11³⁴ дэх заалтуудыг зөрчиж байна.

4.1.2. Аж ахуйн нэгж, байгууллага хуульд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аймгийн хэмжээнд нийт 35 аж ахуй нэгж, байгууллага нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшиж үйл ажиллагаа явуулж байна.

Аж ахуй нэгж, байгууллагын үүргийг Ойн тухай хуулийн 17.3.9³⁵, 22.1.3³⁶, 22.1.11³⁷, 22.2³⁸ дахь заалтад тус тус тодорхойлжээ.

Аж ахуй нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг үзэхэд зарим аж ахуй нэгжийн менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт байхгүй, сумдын ИТХ-аар төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцүүлээгүй зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Сэлэнгэ сумын “Ингэт-Өлзий” ХХК-ний 2018 оны менежментийн төлөвлөгөөний биелэлт, 2019 оны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт нь тухайн аж ахуйн нэгжид байхгүй,
- БОАЖГ-ын ойн мэргэжилтэн солигдсон гэх шалтгаанаар 8 аж ахуйн нэгжийн ойн менежментийн төлөвлөгөөнөөс бусад аж ахуйн нэгжүүдийн менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт байхгүй байна.

Энэ нь шат шатны эрх бүхий байгууллагуудын хяналт сул байгаатай холбоотойгоор аж ахуйн нэгж байгууллагууд дээрх хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

4.1.3. Сум дундын ойн ангиуд хуульд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сум дундын ойн ангийн үүргийг ойн тухай хуулийн 18.3.8³⁹, 18.3.9⁴⁰, 18.3.12⁴¹, дахь заалтад тус тус тодорхойлжээ.

³⁰ ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

³¹ Ойн нөхөрлөл нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөтэй байна.

³² Ойн нөхөрлөл нь хууль тогтоомжид нийцсэн дүрэмтэй байна.

³³ Ойн нөхөрлөл нь сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр явуулж байгаа үйл ажиллагааныхаа хөтөлбөр, ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг жил бүр тавина.

³⁴ Дараах тохиолдолд тухайн сум, дүүргийн Засаг дарга ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж хамгаалах чиглэлээр явуулах ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг зогсоож, гэрээг цуцална:

³⁵ Ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

³⁶ Ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшсэн аж ахуйн нэгж, байгууллага нь энэ хуулийн 4.9, 9.3-т заасны дагуу ойн хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх чиглэлээр явуулах үйл ажиллагааны ойн

³⁷ жил бүр сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ойн хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаар тайлан тавьж, ажлаа дүгнүүлэх;

³⁸ Тухайн сум, дүүргийн Засаг дарга нь ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дараах үндэслэлээр зогсоож, гэрээг цуцална;

³⁹ Аймаг, сумын түвшинд ойн хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;

⁴⁰ Мэдээллийн санг эрхлэх;

⁴¹ Ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, зөрчлийг арилгах

Хутаг-Өндөр сумын сум дундын Ойн анги нь 2018, 2019 оны талбай тусгаарлалтын материалыг нэгтгэж архивын нэгж болгоогүй, хариуцсан 4 суманд хэдэн га талбай тусгаарлалт хийсэн мэдээ тайлан байхгүй, сумдын ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ажиллаагүй, нөхөн сэргээх, үржүүлэх талаар хийгдсэн ажлын баримт материал байхгүй байна.

Булган сумын сум дундын ойн анги нь ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулж, зөрчлийг арилгах, нөхөн сэргээх, үржүүлэх талаар явуулж байгаа бодлогыг хэрэгжүүлж үр дүнг тооцох ажлыг зохион байгуулдаггүй байна.

4.1.4 Ойн тухай хуулийн хэрэгжилтэд орон нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагууд 2018, 2019 онд хяналт шалгалтыг жилд 1-2 удаад тогтмол удирдамжийн дагуу төлөвлөгөөт шалгалтыг зохион байгуулдаг ч тодорхой бодит үр дүнд хүрэхгүй байна.

БОАЖГ нь 2018 онд мэргэжлийн байгууллагатай хамтарч хяналт шалгалт хийхэд мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын шон тэмдэг, тэмдэглэгээ хийгээгүй, технологийн карт байхгүй, огтлолтын төрөл зөрсөн, /цэвэрлэгээний огтлолтоор үйлдвэрлэлийн огтлолт бэлтгэсэн/, хяналтын хуудас байхгүй, БОХУБ, байгаль хамгаалагчийн хяналт сул, мод бэлтгэлийн талбайг хүлээж авдаггүй, Ойн анги технологийн хяналт хийгээгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

ДҮГНЭЛТ:

1. Аймаг, сумдын ИТХ, ЗД, БОАЖГ нь хуульд зааснаар аймаг, сумын түвшинд ойн менежментийн төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар батлуулаагүй, үйл ажиллагаа явуулж буй ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагыг ойн менежментийн төлөвлөгөөг батлаагүй, 2019 оны ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх аймгийн галын төлөвлөгөөг боловсруулаагүй, ойн нөхөн сэргээлтийн ажлын үр дүнг тооцоогүй зэрэг ажлуудыг огт хэрэгжүүлж ажиллаагүй байна.
2. Аймаг, сумын ИТХ, Засаг дарга нар БОАЖГ, Сум дундын ойн ангиуд нь ойн тухай хуулиар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
3. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэх үйл ажиллагааны дээд хэмжээг тогтоосон аймгийн ИТХ-ын тогтоолын хэрэгжилт, мод бэлтгэх эрхийн бичиг, хууль тогтоомжоор төвлөрүүлэх төлбөр, хураамжийн орлогын гүйцэтгэлд БОАЖГ, сумдын ЗДТГ -ын хяналт сул байна.
4. Ойн нөөц ашигласны орлогын төлөвлөгөө давж биелж байгаа нь ИТХ-аар баталсан модны дээд хязгаарыг баримталдаггүй, мод бэлтгэх дээд хязгаараас хэтрүүлэн олгодогтой холбоотой байна.
5. Сумдын түвшинд ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос ойг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхгүй байна.

6. МХГын Улсын байцаагч, БОУБ ойгоос хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэж байгаа боловч үр дүнгээ өгөхгүй байна. Жил бүр орон нутгийн хөрөнгөөр хийсэн ойжуулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналт сул байна.
7. Үнэт цаасны бүртгэл тооцоонд тавих хяналт сул байгаагаас модны эрхийн бичиг дутагдуулж, ойн нөөцийн орлогыг дутуу төвлөрүүлж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Д.Эрдэнэбат танаа:

- Сумдын ИТХ-д ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.1.5, 18.1.6 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэн ажиллах чиглэл өгч, удирдлагаар хангаж ажиллах.

Аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ танаа:

- Аймаг, сумын ойн менежментийн төлөвлөгөөг шинэчлэн батлуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах.
- Сумдын Засаг дарга, ИТХ нь ЗГ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.2. заалтуудыг үндэслэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг сумын суурь зардалд оруулан тооцож тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан холбогдох хууль журмын хэрэгжилтийг ханган ажиллах.
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 “Ойгоос мод бэлтгэх журам” -ын 7 дугаар зүйл заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.
- Сумдын ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж, ашигласны төлбөрийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлд дотоод хяналт шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгч байх.
- Сумдын Засаг дарга нарт ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын гэрээг жил бүр дүгнэх, удаа дараа зөрчлийг давтан гаргасан ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын эрхийг цуцлах арга хэмжээ авах.
- Хутаг-Өндөр сумын сум дундын ойн ангийн 2018, 2019 оны үйл ажиллагааны тайлан болон талбай тусгаарлалтын материал, нөхөн сэргээлтийн мэдээ, өөрийн үйл ажиллагааны барим бичгийн архив нэгж болгох.

Төрийн аудитын байгууллагаас хийсэн санхүү, гүйцэтгэл, нөхцлийн аудитын хураангуй тайлангийн хавсралт

6317144798
ГНОА0048 3190269

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:		2020.12.15	Аудитын нэр:		Ойн тухай хуулийн хэрэгжилтийн үр дүн		Аудитын код:		УАГ-НАГ-2019/07/-НА		
Шалгагдсан байгууллагын нэр:			Аймаг, сумдын ИТХ, ЗДТГ,						төгрөгөөр		
Д/д	Аудитын зорилт, чиглэл	Зөрчсөн хууль, тогтоомжийн зүйл заалт	Алдаа зөрчлийн утга	Тоо	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл					
						нэр	огноо	дугаар	албан тушаал	Овог нэр	
1	• Ойн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, хөрөнгийг хууль журмын дагуу төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх • Ойн нөхөн сэргээлт үр дүнтэй эсэх • Ойн нөхөрлөл, ойн ангиуд хууль тогтоож, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, холбогдох байгууллагууд хуульд заасан холбогдох хяналтыг хэрэгжүүлсэн эсэх	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалын Ойгоос мод бэлтгэх журмын 3.3 дэх "Мод бэлтгэгч талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг урьдчилан төлж, "Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг"-ийг Ойн ангиас эсхүл сум, дүүргийн Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтнаас авна	Мод бэлтгэх 219 ширхэг эрхийн бичгийг дутаасан, орлогыг төсөвт төвлөрүүлээгүй.	1	3579580	Төлбөрийн акт	2020	БУА-2020/06/-НА-01/143	Байгаль хамгаалагч	Д.Нямдорж, Б.Мөнх-Очир	
2		Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалын Ойгоос мод бэлтгэх журмын 3.3 дэх "Мод бэлтгэгч талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг урьдчилан төлж, "Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг"-ийг Ойн ангиас эсхүл сум, дүүргийн Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтнаас авна	"Хан-Алтийн хийши" ААН нь нөхөн сэргээлийн зардалаас 1042.5, талбай тусгаарлалтын зардалаас 325.0 мянган төгрөгийг тус тус төлөөгүй байна.	1	1075000	Төлбөрийн акт	2020	БУА-2020/06/-НА-02/144	Захирал	О.Анхбаяр	
3		Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалын Ойгоос мод бэлтгэх журмын 3.3 дэх "Мод бэлтгэгч талбай тусгаарласан материалыг үндэслэн ойн нөөц ашигласны төлбөр хураамжийг урьдчилан төлж, "Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг"-ийг Ойн ангиас эсхүл сум, дүүргийн Засаг даргын томилсон эрх бүхий албан тушаалтнаас авна	"Балигийн эх" ХХК нь 2018 оны талбай тусгаарлалтын зардалаас 252.5, 2019 оны талбай тусгаарлалтын зардал 557.5 нөхөн сэргээлийн зардал болох 260.7 мянган төгрөгийг тус тус төлөөгүй байна.	1	1530000	Төлбөрийн акт	2020	БУА-2020/06/-НА-03/145	Захирал	Ж.Сэнгээ	
4		Дээрх зөрчил нь ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.9 -д "мэдээллийн санг эрхлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.	Хутаг-Өндөр сумын ойн анги нь 2018-2019 оны талбай тусгаарлалтын орлогын тулгалтыг хийж дутуу төвлөрүүлсэн орлогыг төвлөрүүлэх	1		Албан шаардлага	2020	БУА-2020/06/-НА-01/130	Дарга	А.Гантөмөр	
5		Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"	Булган, Хутаг-Өндөр сумын Ойн ангийн дарга нарт хуульд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай хариуцлага тооцох албан шаардлага	1		Хариуцлага тооцох Албан шаардлага	2020	БУА-2020/06/-НА-01/127	Засаг дарга	Б.Ариун-Эрдэнэ	
6	Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно"	Хамгаалалтын бүсийн 1 дүгээр мужлаас олгосон түмэнзэний модны үнийг ашиглалтын бүсийн 3 дугаар мужлалаар тооцон Бугат сумын 1 дүгээр багийн байгаль хамгаалагч 670.6, 3 дугаар багийн байгаль хамгаалагч 2065.5, Орхон сумын 1, 2, 4, байгаль хамгаалагч нар 6252.4, нийт 8988.5 мянган төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.	1	8988500	Хариуцлага тооцох Албан шаардлага	2020	БУА-2020/06/-НА-01/126	Дарга	А.Гантөмөр		
Нийт дүн				6	15173080						